

Теологийн байр сууриа бүрдүүлэх нь

Хичээл 1

ТЕОЛОГИ ГЭЖ ЮУ ВЭ?



THIRD MILLENNIUM

MINISTRIES

Biblical Education. For the World. For Free.

For videos, study guides and other resources, visit Third Millennium Ministries at thirdmill.org.

© 2012 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ©1990 номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан. Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Агуулга

| | |
|---|-----------|
| I. УДИРТГАЛ | 1 |
| II. Тодорхойлолт | 1 |
| A. Нийтлэг тодорхойлолтууд | 1 |
| 1. Thomas Aquinas Фома Аквинский | 2 |
| 2. Charles Hodge Чарльз Ходж | 3 |
| 3. William Ames Вильям Эймс | 4 |
| 4. John Frame Жон Фрэйм | 4 |
| B. Tendencies Үзэл хандлагууд | 4 |
| 1. Academic Orientation Судалгааны чиг хандлага | 5 |
| 2. Life Orientation Практик чиг хандлага | 5 |
| C. Evaluations Үнэлэлт дүгнэлтүүд | 6 |
| 1. Academic Orientation Судалгааны чиг хандлага | 6 |
| 2. Life Orientation Практик чиг хандлага | 7 |
| III. Зорилго | 9 |
| A. Primary Goals Үндсэн зорилго | 9 |
| 1. Orthodoxy Ортодокс | 9 |
| 2. Orthopraxis Ортопраксис | 11 |
| 3. Orthopathos Ортопафос | 12 |
| B. Interdependence Харилцан хамаарал | 13 |
| 1. Orthodoxy Ортодокс | 13 |
| 2. Orthopraxis Ортопраксис | 14 |
| 3. Orthopathos Ортопафос | 15 |
| C. Priorities Нэн тэргүүний зүйлс | 15 |
| IV. Хэлэлцэх асуудал | 17 |
| A. Options Хувилбарууд | 17 |
| B. Selections Сонголтууд | 18 |
| V. Дүгнэлт | 19 |

Теологийн байр сууриа бүрдүүлэх нь

Нэгдүгээр хичээл

ТЕОЛОГИ ГЭЖ ЮУ ВЭ?

УДИРТГАЛ

Явах тодорхой чиглэл, төлөвлөгөөгүй зүгээр л алхах заримдаа аятайхан байдаг. Гэхдээ хэрэв хүн хүрэх зорилготой бол, тодорхой цаг хугацаанд тодорхой газар байх ёстой бол газрын зураг, төлөвлөгөө ч юмуу явах чиглэлтэй байсан нь дээр.

Энэ багц хичээлүүдийг “Теологийн үзэл бодлоо бүрдүүлэх нь” хэмээн нэрлэсэн байгаа. Ертөнцийн Эзэний сургаалын талаарх байр сууриа зөв бүрдүүлэх нь маш чухал учраас уг зорилгод хүрэхийн тулд төлөвлөгөө хэрэгтэй. Тиймээс энэ багц хичээлүүдээр бид Христ-Итгэлийн теологоо зөв бүрдүүлэхийн тулд мөрдөх үндсэн, чухал чиглэлүүдийг судална.

Эхний хичээлээ “Теологи гэж юу вэ?” гэж нэрлэсэн. Бид энэ асуултанд хариулахын тулд теологи судлах нэгэн аргыг үзнэ. Уг арга нь өнгөрсөн үеийн сүмд үр өгөөжөө өгсөн бөгөөд өнөөдөр ч дагууштай арга юм. Энэ аргыг судлахын тулд хичээлээ бид гурван үндсэн хэсэгт хувааж, нэгдүгээрт, теологийн тодорхойлолтыг, хоёрдугаарт теологийн зорилгыг, гуравдугаарт теологийн хэлэлцэх асуудлуудыг авч үзнэ.

“Теологи” гэсэн үг ямар утгатай болохыг эхлээд тодорхойлъё. Бид энэ сэдвийг судлахдаа гурван зүйлийг авч үзнэ. Эхлээд дөрвөн теологчийн дэвшүүлсэн нийтлэг хэдэн тодорхойлолтыг үзнэ. Дараа нь тэдгээр тодорхойлолтын зарим үзэл хандлагын талаар ярина. Сүүлд нь тэдгээр үзэл хандлагыг дүгнэж цэгнэнэ. Эхлээд теологийн ухааныг теологчид хэрхэн тодорхойлсныг үзье.

Тодорхойлолтууд

Ромын нэгдүгээр бүлэгт бүх хүн бүх амьдралынхаа турш теологтой холбогддог гэсэн чухал утга санааг илэрхийлсэн байдаг. Үл итгэгчид хүртэл түгээмэл илчлэлтэй тулгардаг бөгөөд үүний улмаас Ертөнцийн Эзэн хийгээд түүний шударга шаардлагуудын талаар заримдаа өөрийн мэдэлгүй эргэцүүлдэг ажээ. Харин итгэгчид ямар мэргэжилтэй байхаасаа үл хамааран Ертөнцийн Эзэний тухай олонтаа бодож явдаг. Харин бид теологийг илүү албан ёсны зорилгоор буюу хамтын чармайлтаар, гүн гүнзгий судалдаг мэдлэгийн салбар гэсэн үүднээс нь үзнэ.

Нийтлэг тодорхойлолтууд

Христэд итгэгчид болон үл итгэгчид теологийг албан ёсны мэдлэгийн салбарынх нь хувьд маш олон янзаар тодорхойлсон байдаг. Харин бид энэ удаа теологийн албан ёсны судалгааны талаар ярьж эхлэхдээ, маш хүндтэй, Христ-Итгэлт дөрвөн

теологчид л анхаарлаа хандуулна. Тэд бидэнд хэрэгтэй чиг баримжаа олгодог юм. Ингээд Фома Аквинский, Чарльз Ходж, Вильям Эймс болон орчин үеийн теологч Жон Фрэйм нарын зохиол бүтээлд теологийг хэрхэн тодоройлсныг харья.

Фома Аквинский

Нэгдүгээрт, алдартай католик теологч Фома Аквинский теологийн маш эртний уламжлалт тодорхойлолтыг төлөөлдөг. Түүний үзэл бодол өмнөх теологчдынх нь туршлагаас үүдсэн бөгөөд одоо ч сүмийн олон салбарт нөлөөтэй хэвээр байна. Аквинский “Теологийн шаштир” хэмээх алдартай зохиолынхоо 1-р ботийн, 1-р бүлгийн 7-р хэсэгт теологийг “ариун номлол” гэж нэрлээд:

“Энэ бол нэгдмэл шинжлэх ухаан бөгөөд уг шинжлэх ухаанаар бүх зүйлийг Ертөнцийн Эзэнтэй холбоо харилцаанд авч үздэг. Яагаад гэвэл юмс нэг бол Түүнтэй шууд холбогддог, эсвэл Түүн рүү чиглэдэг” гэж тодорхойлсон.

Теологийн оюутнуудад энэ тодорхойлолт нэлээд боломжийн санагддагийн зэрэгцээ ихэнх хүнд тун ойлгомжтой. Үүнд онцгой анхаарал хандуулвал зохих хоёр чухал тал бий.

Нэгд, Аквинский теологийг “шинжлэх ухаан” гэж тодорхойлсон. Гэхдээ тэр “шинжлэх ухаан” гэдэг үгийг орчин үеийн утгаар нь бус, оюуны буюу эрдмийн судалгаа гэсэн өргөн утгаар нь хэрэглэжээ. Энэ утгаар теологи бол тодорхой зорилготой эрдмийн үйл хэрэг юм. Зарим хүн биологи, сэтгэл судлал, хууль ч юмуу түүхийг судалдаг шиг эрдэм мэдлэгийн салбар гэсэн үүднээс нь теологоор замнасан хүмүүс байдаг гэдгийг Аквинскийн тодорхойлолт илэрхийлдэг. Теологийн энэ ойлголт үндсэндээ эрдмийн судалгаатай холбоотой үйл ажиллагаагаар дамжин гүйцэлддэг.

Энэ үзлээр, теологчийн ажил бол үндсэндээ теологийн онол, ойлголтуудын талаар тунгаан бодох, заах, бичих юм. Фома Аквинский мэдээж, теологи зөвхөн эрдмийн ажил байх нь зүйтэй гэж үзээгүй, харин Христэч амьдралын талбар бүрт нөлөөлөх ёстой гэж үзсэн байна. Гэхдээ тэр теологийг үндсэндээ оюуны ажил гэж үзэх хандлагатай байжээ.

Аквинскийн бичсэн теологийн тодорхойлолтод хоёр дахь чухал тал байдаг. Теологи доод тал нь хоёр түвшинтэй гэж тэр үзжээ. Нэг талаар, теологчид “Ертөнцийн Эзэнд Өөрт нь” хамаарах асуудлуудыг авч үздэг. Жишээлбэл, бид Ертөнцийн Эзэний бүхнийг мэдэгч, хаа сайгүй оршигч, ариун шинж чанар гэх мэт асуудлуудын талаарх үзэл санааг томъёолдог. Бид эдгээр сэдвийг “жинхэнэ теологи” гэж нэрлэдэг бөгөөд энэ түвшинд Ертөнцийн Эзэн Өөрөө бидний судлагдахуун юм.

Нөгөөтэйгүүр Аквинскийн тодорхойлсноор теологийн ухаан Ертөнцийн Эзэнд хамаарах буюу Түүн рүү чиглэх бусад сэдвийг ч судалдаг. Эдгээр сэдвийг Ертөнцийн Эзэнд онцлон хамааруулахгүйгээр авч хэлэлцэж болох ч теологчдийн ажил бол тэдгээрийг Ертөнцийн Эзэнтэй холбоо харилцаанд авч үзэх юм. Нөгөөтэйгүүр Аквинскийн тодорхойлсноор теологийн ухаан Ертөнцийн Эзэнд хамаарах буюу Түүн рүү чиглэх бусад сэдвийг ч судалдаг. Эдгээр сэдвийг

Ертөнцийн Эзэнд онцлон хамааруулахгүйгээр авч хэлэлцэж болох ч теологчдийн ажил бол тэдгээрийг Ертөнцийн Эзэнтэй холбоо харилцаанд авч үзэх юм.

Жишээлбэл, эцсийн үеийн талаар судалдаг эсхатолог бол теологийн нэг чухал сэдэв. Мөн гэм, золиост авралийн онол болон Их Эзэний зоогийн үеэрх Христийн оршихуйн асуудал гэх мэт сэдвүүд ч “жинхэнэ теологт” хамаарахгүй боловч теологи гэсэн гарчгийн дор ордог.

Аквинскийн тавьсан үндсэн чиг баримжааг мэдсэн тул одоо Протестант теологч Чарльз Ходж төстэй зүйл хэлснийг сонсоход таатай байх болно..

Чарльз Ходж

Хэдийгээр Протестант Шинэчлэл Христийн биеийн олон зүйлийг өөрчилсөн боловч теологийн үндсэн тодорхойлолт тэгтлээ их өөрчлөгдөөгүй. Принстоны Чарльз Ходж 1797-1879 оны хооронд амьдарч байсан бөгөөд “Системт теологи” номынхоо эхний бүлэгт: “Теологи бол Ертөнцийн Эзэний мөн чанар болон Түүнтэй бид ямар холбоо хамааралтай болох талаарх тэнгэрлэг илчлэлийн баримтуудыг судалдаг шинжлэх ухаан юм.” гэж тодорхойлсон.

Теологийн энэ тодорхойлолтын хэд хэдэн талыг харья. Нэгд, Ходжийн тодорхойлолт Аквинскийн тодорхойлолттой тун төстэй боловч “илчлэл” гэдэг үгийг илэрхий дурдсан. Тэрбээр теологи “тэнгэрлэг илчлэлийн баримтууд”-ыг авч үздэг гэсэн. Аквинский ч гэсэн мэдээж теологоо Ертөнцийн Эзэний илчлэлд суурилахыг эрмэлзсэн. Гэхдээ Ходжийн тодорхойлолт Ертөнцийн Эзэний илчлэлийн чухлыг, ялангуяа Библийг теологийн нөөц баялгаа болгон онцолж Протестантантизмын нийтлэг чухалчлах зүйлийг илэрхийлсэн.

Хоёрт, Ходж ч Аквинскийтэй адил теологийг шинжлэх ухаан гэж тодорхойлсныг анзаарах нь чухал. Тэр теологийг үндсэндээ эрдмийн салбар гэж үзсэн. Ходж тухайн үеийнхээ байгалийн болон физикийн шинжлэх ухааны аргачлалуудыг теологчдын мөрдөх загвар болгон ашигласан байдаг. Тэр “Системт теологи” номынхоо эхний хуудсанд:

“Байгаль хими буюу механикийн систем болохын адил Библи теологийн систем юм. Байгальд баримтууд байх ба химичид ч юмуу механик философичид уг баримтуудыг нөхцөлдүүлсэн хууль, зүй тогтлыг тогтоохын тулд судалж шинжилдэг. Үүнчлэн теологчдын цуглуулж, үнэн зөв болохыг нь нотолж, системчилж, харилцан бие биедээ харуулах ёстой үнэнг Библи агуулдаг.” гэсэн байдаг.

Теологчийн ажил бол Библийг баримт мэдээлэл болгон ашиглаж, 19-р зууны үеийн бусад салбарын эрдэмтэдтэй адил уг баримтаа судалж шинжлэн, эмхэлж цэгцлэх юм гэж Ходж үзэж байжээ. Мөн тэр теологчдын дүгнэлт Христэд Итгэгчдийн амьдралд хэрэгжих хэрэгтэй гэж үзэж байсан боловч Аквинскийн нэгэн адил хэрэгжилтийн асуудлыг пастор, ахлагч нарт орхиж, албан ёсны теологийн ажлыг ихэвчлэн эрдэмтэд, оюутнуудад үлдээсэн байна.

Гуравдугаарт, теологи “Ертөнцийн Эзэний мөн чанар”, “түүнтэй холбодох бидний холбоо хамаарал” гэсэн хоёр үндсэн сэдэвтэй гэж Ходж мөн үзсэн.

Аквинский теологийг дотор нь жинхэнэ теологи, ерөнхий теологи хэмээн хоёр хувааж байсантай энэ ангилал дүйнэ.

Аквинский, Ходж нар теологийг хэрхэн тодорхойлсон талаарх төсөөлөлтэй болсон тул гурав дахь тодорхойлолт руу ороход дөхөмтэй. 1576- 1633 оны хооронд амьдарч байсан нөлөөтэй Пуритан Вильям Эймс теологийн талаар арай өөр зүйл хэлсэн.

Вильям Эймс

Тэрбээр “Теологийн мөн чанар” номынхоо эхний хэсэгт теологийн мөн чанарыг “Ертөнцийн Эзэний өмнө амьдрах амьдралын онол буюу сургаал” гэжээ.

Теологийн талаарх Эймсийн үзэл бидний саяны үзсэн үзэл бодлуудаас наад зах нь хоёр талаараа ялгаатай. Нэгд, түүний тодорхойлолтод “шинжлэх ухаан” гэдэг үг байдаггүй. Харин тэр “онол буюу сургаал” гэснээрээ теологийг оюуны эрэл хайгуул гэж үзжээ. Аквинский, Ходж нараас ялгаатай нь тэр теологийг эрдмийн бусад салбартай тийм ойр уялдаа холбоотой гэж үзээгүй.

Хоёрт, Эймс теологийг онолын судалгаа гэж үзэхдээ судалгааны сэдвийг нь: “Ертөнцийн Эзэний өмнө амьдрах талаар” гэж тодорхойлсон. Аквинскийгаас гадна Ходж ч ямар нэг хэмжээгээр теологийг гол нь баримт, үзэл бодлуудын цуглуулга гэж үзсэн бол Эймс теологийг хүн Ертөнцийн Эзэний өмнө, Түүний төлөө хэрхэн амьдрах талаарх асуудлыг судалдаг гэж үзсэн. Гэхдээ тэр теологийг оюуны ба баримтын эрэл хайгуул хийдэг ухаан гэдгээр хязгаарлаагүй, харин Пуританчуудын нэрлэснээр “туршлага”-тай, улмаар Христэд итгэгчдийн амьдралтай холбон өргөжүүлсэн. Теологийн мөн чанар үүнд байна гэж тэр үзсэн байна.

Орчин үеийн теологч Жон Фрэйм Эймстэй үзэл бодол нийцдэг.

Жон Фрэйм

Фрэйм “Ертөнцийн Эзэний талаарх мэдлэгийн онол” номынхоо 3-р бүлэгт теологийг: “Ертөнцийн Эзэний үгийг хүмүүс амьдралынхаа талбар бүрт хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Фрэйм номондоо “хэрэгжилт” гэдгийг мөн “сургаал, номлол” гэж тодорхойлсон байдаг тул зарим талаар Аквинский, Ходж нартай санал нийлдэг гэсэн үг. Гэхдээ сургаал номлол гэдэг бол Бичээсийг ашиглан “хүмүүсийн хэрэгцээг хангах” үйл ажиллагаа гэж тэр үзжээ. Теологи бол уламжлалт, судалгааны талын цогц асуудлын талаарх бодол эргэцүүлэл төдий биш, харин Бичээсийн номлолуудыг амьдралын өргөн хүрээнд хэрэгжүүлэх явдал юм, теологи гэдэг бол хэрэгжүүлэлт юм гэж тэр үзсэн байна.

Бид теологийн дөрвөн өөр тодорхойлолт үзсэн тул уг тодорхойлолтууд ямар чиг хандлагуудыг төлөөлдөг болохыг харьцуулж үзэхэд дөхөмтэй байх болно.

ҮЗЭЛ ХАНДЛАГУУД

Энэ дөрвөн тодорхойлолт дахь хоёр чухал үзэл хандлагыг теологчид авч үздэг. Нэгийг нь судалгааны чиг хандлага, нөгөөг нь амьдралын чиг хандлага гэж нэрлэж болох юм.

Судалгааны чиг хандлага

Нэг талаас Аквинский, Ходж нар теологийн судалгааны буюу онолын чиглэлийг төлөөлдөг юм. Христэч теологчдийн ихэнх нь теологийг гэдэнтэй адил арга замаар тодорхойлдог. Тодруулбал, тэд теологийг үгийн гарлаар нь буюу хэл шинжлэлийн үүднээс тодорхойлдог юм. “Теос” гэдэг нь Грекээр “Ертөнцийн Эзэн” гэсэн утгатай бөгөөд энэ үг “теологи” гэдэг үгийн эхний хэсгийг бүрдүүлдэг. Харин “логос” гэдэг Грек үг энд “шинжлэх ухаан, онол, эсвэл судалгаа” гэсэн утгыг илэрхийлж байгаа бөгөөд энэ үг “теологи” гэдэг үгийн үлдсэн хэсгийг бүрдүүлж байна. Тиймээс үгийн гарал зүйн үүднээс бол “теологи” гэдэг нь “Ертөнцийн Эзэний онол буюу судалгаа” гэсэн утгатай.

Зөвхөн Ертөнцийн Эзэний тухай судлах нь теологийн эцсийн зорилго гэж үнэн сэтгэлээсээ хэлэх евангели чиглэлийн теологч бараг олдохгүй. Теологи ямар нэг байдлаар бидний амьдралд хэрэгжих учиртай гэдгийг ихэнх итгэгч ойлгодог. Гэхдээ хэрэгжилтийн асуудал албан ёсны теологт төдий л чухал биш бөгөөд хэрэгжилтийг дараагийн алхам буюу албан ёсны теологийн эрдмийн, судалгааны асуудлуудыг шийдсэний дараа хоёр дахь салбар маягаар барьж авах зүйл гэж ихэвчлэн үздэг. Үүнийг практик теологи ч гэж нэрлэх нь бий.

Тиймээс албан ёсны теологи энгийн амьдралд тун бага анхаарал хандуулж байж болно. Ингэснээр теологи нь эрдэм судлалын авьяастай цөөхөн хүн л гүнзгий оролцдог салбар болон үлдэж, теологт оюуны мэргэжилтнүүдийн үзэл санаа гэмээр зүйл боловсрон хөгждөг байна.

Нөгөөтэйгүүр бидний түрүүн үзсэн, Эймс, Фрэйм нарын тодорхойлолт цөөнхийн чухал үзэл санааг буюу теологийн практик чиг хандлагыг төлөөлдөг.

Практик чиг хандлага

Теологийг итгэгч хүний амьдралын өргөн цар хүрээтэй нягт холбоотой гэж үздэг теологчид үргэлж байсаар байгаа. Гэхдээ өмнө нь энэ үзлийг тэргүүлэх цөөн теологч баримталдаг байсан бол сүүлийн жилүүдэд теологи зөвхөн оюуны асуудлуудтай хамаатай гэсэн үзлийг няцаадаг теологч олшироод байгаа. Тэд албан ёсны теологийг Христэч амьдралын оюуны буюу цэвэр онолын суурь төдий биш, Христийн төлөөх амьдралтай гүн гүнзгий хамааралтай эрдмийн салбар гэж үздэг.

Цөөнхийн энэ үзэл бодол ойрын хэдэн арван жилд илүү олон дэмжигчтэй болсонд олон шалтгаан бий. Зарим шалтгаан нь теологоос болон бүр Бичээсээс хүртэл урган гарсан. Гэхдээ салбар чиглэл, мэдлэг чадвар үл харгалзан, мэргэжилтэн шинжээчдийн бодитой байх чадварт эргэлзэх хандлага барууны соёлд бий болсноос үүдэн теологийн практик чиг хандлагыг улам олон хүн дэмжих болсныг бид мөн мэдэж байх нь зүйтэй. Сэхээтнүүд ч хүний мөн чанартайг, мөн

тэдний амьдрал судалгааны ажилд нь гүнзгий нөлөөлдгийг бид олонтаа харах болсон.

Жишээлбэл, эрдэмтэд хийгээд анагаахын мэргэжилтнүүдийг хүмүүс жинхэнэ бодитой дүгнэлт гаргадаг гэж нэгэн цагт боддог байсан бол одоо тэднийг жирийн хүмүүс гэж үзэх болсон. Одоо бид тэдний санал бодолд байнга эргэлзээтэй ханддаг нь ердөө хорь гучхан жилийн өмнө санаанд багтамгүй зүйл байсан. Үүний адилаар теологч хэчнээн ч мундаг байсан, мөн л жирийн хүн гэдгийг сүм илүү сайн ухаарах болсон юм. Хэдийгээр тэд баримтуудыг бодитойгоор ажигладаг гэж мэдэгдсэн ч амьдралынх нь туршлага тэдний үзэл бодолд гүнзгий нөлөөлдөг. Тиймээс теологийн цэвэр онолын хандлага өдгөө хамаагүй бага унэлэгдэх болж, хэрэгжилтийн хэрэгцээ урьд урьдынхаас улам тодорхой харагдах болсон.

Теологийн онолын болон практик чиг хандлагын талаар ерөнхий ойлголттой болсон тул одоо зарим нэг урьдчилсан үнэлэлт дүгнэлт хийе.

ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТҮҮД

“Энэ хоёр хандлагад ямар ямар давуу тал, сул тал байна вэ? Албан ёсны, нухацтай теологи дахь онолын болон амьдралын чиг хандлагын эерэг болон сөрөг талууд юу вэ?” гэсэн асуултууд үүнд хэрэг болно.

Судалгааны чиг хандлага

Нэгдүгээрт, хүн төрөлхтөнд өгсөн Ертөнцийн Эзэний нигүүлсэнгүй бэлгүүдийн нэг болох оюун дүгнэлт хийх чадварыг тулгуур болгодог нь онолын чиг хандлагын хүчтэй тал юм. Ертөнцийн Эзэн хүмүүст оюуны чадвар хайрласан бөгөөд уг чадвараа үнэний эрэлд ашиглаасай гэж теологчдоос хүсдэг.

Ертөнцийн Эзэнээс эмээхээ умарталгүйгээр оюуны чадамжаа ашигласан цэцэн хүмүүсийг Бичээст олонтаа магтсан байдаг. Үнэний мөн чанарыг анхааралтай тунгаан, оюуны тэр шинжилгээнээсээ итгэл үнэмшил томъёолон гаргаж ирэх нь ухаалаг байхын нэг салшгүй хэсэг юм. Соломон аливаа асуудлуудыг тал бүрээс нь тунгаан бодоход оюуны чадвараа ашиглаж байсан учраас цэцэн ухаантай байсан юм.

Соломоныг хэрхэн тодорхойлсныг Хаадын дээдийн 4-р бүлгийн 29, 31-р ишлэлээс харья.

“Ертөнцийн Эзэн Соломонд далайн эрэг дээрх элс мэт энгүй их цэцэн билэг, нэвтэрхий, уудам ухаан өгчээ... Тэр ямар ч хүнээс илүү ухаантай байлаа... Түүний алдар цуу зэргэлдээх бүх улсад нь цууриатжээ.” гэсэн байдаг.

Түүнчлэн оюун дүгнэлт хийх чадвараа хөгжүүлэх, ашиглах нь зүйтэй гэж Библийн цэцэн билгийн зохиолууд бидэнд хэлдэг юм.

Тухайлбал, Пуулийн теологи оюун ухааны хувьд нарийн боловсронгуй гэж Пэтр магтсан байдаг. 2-р Пэтрийн 3-р бүлгийн 15, 16-р ишлэлд тэрбээр:

Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн...Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг.

Уламжлалт теологи оюуны болон онолын талд онцгой анхаардаг нь сайн теологийн талаарх Библийн ойлголтыг сэргэдөггүй. Харин ч нягт нарийн сэтгэлгээ бол уламжлалт теологийн үлэмж хүчтэй тал юм.

Гэхдээ онолыг голчлох энэ чиглэлийн ард нэг аюул нуугдаж байдгийг бид мөн адил онцлох ёстой. Уламжлалт теологи онолын асуудлуудад хэт төвлөрөөд, номын сангийн гаднах теологчийн амьдралыг тун бага анхаарах явдал олон тохиолддог нь харамсалтай. Тодорхой үзэл санаануудыг зөв томъёолох нь теологийн ганц зорилго болж, теологийн ухааны талаар ихийг мэддэг хүнийг л сайн теологч гэж үзэх нь элбэг. Гэхдээ “сайн теологч” бүр “сайн хүн” байдаггүй гэдгийг заримдаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог.

Харамсалтай нь энэ дүгнэлт дэндүү олон “сайн теологч” гэгчид таардаг. Тэд Ертөнцийн Эзэн болон Христ-Итгэлийн амьдралын талаарх баримтуудыг гарамгай ур чадвараар цуглуулж, эмхэлж чадах боловч Христ-Итгэлийг үндэс болгон амьдрахад тэр хэмжээний анхаарал тавьж чаддаггүй.

Ямар үед “сайн теологч боловч сайнгүй хүн байж магадгүй” гэсэн бодол төрдөг вэ? Тухайн теологчийн тодорхойлолт зөвхөн онолын үйл ажиллагааг хамарсан байвал, теологи гэдэг нь ердөө сайн судлах, сайн ном бичих, зөв ойлголтуудыг заах юм гэсэн байвал “сайн теологч, сайнгүй хүн” байж мэдэх юм.

Харамсалтай нь өнөөгийн теологийн албан ёсны сургалтад энэ хандлага давамгайлсаар байна. Теологийн сургуулиуд бараг зөвхөн танхимын сургалтанд тулгуурлан сайн мэдээний үйлчлэгчдийг бэлтгэдэг. Энэ нь бид өдгөө ч теологийн ухаан нь теологийг амьдралд хэрэгжүүлэхээс үлэмж хэмжээгээр ангид байж болно гэж үзсээр байгааг илэрхийлдэг. Албан ёсны теологт хандах уламжлалт хандлагын хамгийн том аюулуудын нэг энэ юм.

Практикт чиглэсэн теологт давуу болон сул талууд мөн байдаг. Теологи сургалт судалгаатай гэхээсээ илүү амьдралтай шууд холбоотой байх хэрэгтэй гэсэн ойлголтыг улам олон хүн санаа нэгтэйгээр дэмжих болсныг бид хэрхэн үнэлж дүгнэвэл зохих вэ?

Практик чиг хандлага

Нэгдүгээрт, Библийн эрхэмлэх зүйлсийг мөрдөхөд бидэнд түлхэц болдог нь теологийн энэ хандлагын үлэмж хүчтэй тал юм. Тухайлбал бид бүгд Иаков 1-р бүлгийн 22-р ишлэлийг мэднэ. Иаков энд:

“Үгийг сонсох төдийгөөр өөрсдийгөө хуурах бус, биелүүлэгтүн.” гэж бичсэн.

Бичээсийн энэ үгс олон теологчийн хоёр нүүртэй байдлыг бүрэн урьдчилан хэлжээ. Зөв теологи зөвхөн зөв зохистой суралцахад биш, зөв амьдралд хөтөлнө.

Пууль 1-р Коринф 8-р бүлгийн 1-р ишлэлд:

“Мэдлэг ихэрхэг болгодог бол хайр сургамжилдаг.”

Мөн 1 Коринфийн 13-ийн 2-т:

“Би бүх үл ойлгогдох байдал, бүх мэдлэгийг ухааж ойлгосон ч, надад хайр үгүй бол би юу ч биш.” гэж хэлэхдээ энэ санааг илэрхийлсэн биш үү.

Бид теологийг бодитой ойлголтод тулгуурласан аргаар судлахад л анхаарвал Библийн жишгийг хангаж чадахгүй. Харин Бичээст үндэслэсэн теологи бидний итгэл үнэмшилийг тодорхойлдог юм.

Гэхдээ теологийн практик чиг хандлага нь “оюунлаг байдлыг эсэргүүцэх” гэсэн ноцтой эрсдэл буюу аюул учруулдаг. Өнөөдөр Евангели Христчид олноороо теологийн оюуны талд огт итгэдэггүй учраас теологийн онолыг нарийн нягт судлахын эсрэг эргэсэн. Тэд үнэндээ онолд чиглэсэн, уламжлалт, албан ёсны теологи Христ-Итгэлийн амьдралд хор уршигтай гэж үздэг.

Илэн далангүй хүмүүс: “Онол яриад хэрэггүй дээ. Онолдох нь бидний оюун бодлыг Христээс холдуулахаас цаашгүй” гэж ярихыг бид бүгд сонссон. Эсвэл: “Сүмийн ахлагч болохын тулд теологи судлах шаардлагагүй. Танд зүгээр л ариун сүнсний удирдлага хэрэгтэй.” гэж ярихыг та сонссон байж магадгүй. Би саяхан: “Онолын Христ-Итгэл бол үхмэл Хрис-Итгэл” гэхийг сонслоо. Уг нь буруу санаагүй энэ итгэгчид уламжлалт, онолд чиглэсэн теологт илэрхий дургүйцэж, хүлээн авахаас татгалзан, Христ-Итгэлд хандах оюунлаг хандлагыг эсэргүүцдэг юм. Иймэрхүү итгэгчид амьдралаа нямбай, бүр

яг таг боловсруулсан теологт үндэслэхийн оронд зүгээр л өөрсдийн сүнслэг зөн совинд түшиглэж, магадгүй нэг нөлөө бүхий ч юмуу каризматик удирдагчаас үлгэр авдаг байна. Эсвэл тэд уламжлалт, онолын теологийг ер бусын сүнслэг явдлуудаар орлуулдаг. Гэхдээ оюунлаг байдлыг эсэргүүцэх нь буруу сургаал руу болон Христ-Итгэлийг буруу ойлгоход гарцаагүй хөтөлж, улмаар энэ нь олон итгэгчийн амьдралд уршиг тарьдаг. Тиймээс ямар ч нөхцөлд оюунлаг байдлыг эсэргүүцсэнээс үүдэх энэ ноцтой эрсдлүүд сүмд гарахыг бид бүгд эсэргүүцэх хэрэгтэй..

Пууль энэ аюулыг мэдэж байсан тул:

“Чи ичих явдалгүй бөгөөд үнэний үгийг зөв хэрэглэдэг ажилчин гэдгээ, тааламжит хүн болохоо Ертөнцийн Эзэнд харуулахын тулд чадах бүхнээ хийгтүн.” гэж Тимотод сануулсан нь 2-р Тимотын 2-р бүлгийн 15-р ишлэлд байдаг.

Хүн бүр теологийг яаж тодорхойлж байгаагаа сайн бодож үзэх хэрэгтэй. Та биднээс зарим нь аяндаа л теологийн онолын хандлага руу чиглэж, амьдралын бусад талд хайхрамжгүй ханддаг бол зарим нь онолын асуудлуудыг үл хайхран практик чиглэл рүү ханддаг. Ийнхүү туйлшрахаас зайлсхийхийн тулд энэ хоёр үзэл бодлын аль алинд эрсдэл болоод ач холбогдол байгааг зөвшөөрөх хэрэгтэй. Энэ 2

үзэл бодлын аль алиныг хүлээн авах нь ухаалаг хэрэг бөгөөд онолд чиглэсэн теологч, амьдралд чиглэсэн теологч ч бидэнд хэрэгтэй юм.

Теологчид теологийг ямар ямар арга замаар тодорхойлсон талаар үзсэн тул одоо хоёр дахь сэдэв рүүгээ буюу теологийн зорилго руу орьё. Теологийг судлах үед эн тэргүүнд тавих зорилгууд юу вэ? Эдгээр зорилго өөр хоорондоо хэрхэн холбогддог вэ?

Зорилго

Энэ хоёр асуултанд хариулахын тулд бид гурван зүйлийг үзнэ. Нэгд, теологийн үндсэн гурван зорилгыг тодорхойлно. Хоёрт, энэ гурван зорилгын харилцан хамаарлыг судална. Гуравт, энэ гурван зорилгод ямар нэн чухалчлах зүйлс байх ёстойг үзнэ. Эхлээд теологийн зорилгуудыг тодорхойлье.

Үндсэн зорилго

Теологийн зорилгуудыг маш олон янзаар тодорхойлж болох тул тэр бүгдийг жагсаах боломжгүй. Ерөнхийдөө, Христэд итгэгч бид юуны төлөө бүхнийг хийдэг билээ мөн тэр л зорилгуудын төлөө теологийг судалдаг. Вэстминстерийн товч сургаалын 1-р асуултанд теологийг: “Ертөнцийн Эзэнийг алдаршуулж, түүнтэй харилцан үүрд баярлах” арга замуудын нэг юм гэсэн. Гэхдээ үүнээс нарийн тодорхойлох боломжтой. Учир нь Ертөнцийн Эзэнийг алдаршуулж, Түүнд талархан баярлахад теологи онцгой чухал үүрэгтэй билээ.

Теологийн тодорхойлолтуудын ялгаа нь теологийн хэд хэдэн зорилгыг ялгаж салгах эхлэлийн цэг болдог. Албан ёсны теологийг юуны өмнө шинжлэх ухаан, эрдэм мэдлэгийн нэг салбар гэж тодорхойлсон нь теологи нэг талаар оюуны зорилготой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, теологи нь оюуны асуудлуудад чиглэсэн онолуудыг заах, боловсруулах гэсэн нэг зорилготой. Нөгөө талаар, теологийг практик чиг хандлагатай гэж тодорхойлдог нь теологи бол Христтэй нэгдсэн бидний амьдралын өргөн хүрээний асуудлуудад чиглэсэн сургаал, онолуудыг боловсронгуй болгох бас нэг зорилготой гэсэн үг.

Бид теологт хандах энэ хоёр чиг хандлагад үндэслэн ортодокс, ортопрактик болон ортопафос гэсэн теологийн үндсэн гурван зорилгын талаар ярина. Эхлээд теологийн ортодокс зорилгын талаар үзье.

Ортодокс байдал

Нэгдүгээрт, онолын ортодокс байдал бол ямарваа үнэн зөв, Христэд теологийн үндсэн зорилго юм. “Ортодокс байдал” гэсэн нэр томъёог өөр өөр сүмүүд өөр өөр утгаар хэрэглэдэг бол бид энэ нэр томъёог: “зөв номлолыг дагах” гэсэн энгийн утгаар энд хэрэглэнэ. Ортодокс байдлын зорилго бол үнэнд нийцсэн

зөв номлолыг бий болгох явдал юм. Бид ямар урсгал, ямар сүмийнх байхаасаа үл шалтгаалан итгэлийг тодорхойлохдоо теологи нь үнэнийг баримтална. Ертөнцийн Эзэн болон биднийг тойрон хүрээлж буй орчлонгийн талаар, өөрсдийнхөө талаарх бидний ойлголт үнэнд нийцсэн байх нь зүйтэй юм. Теологийн түүхэнд ортодокс нэлээд чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Теологийн ихэнх бүтээлийн хувьд номлолын цэвэр ариун байдлыг нэн тэргүүнд анхаарч ирсэн нь мэдээж хэрэг юм.

Жишээ нь “Системт теологи” 3-р бүлгээс “Христ- хувь хүн ба түүний ажил” хэмээх Луис Беркхофын бүтээлийг авч үзье:

Христ хувь хүн болох нь

- I. Түүхэн дэх Христийн тухай номлол
- II. Христийн нэр ба мөн чанар
- III. Христийн хувь мөн чанарын нэгдэл

Христийн байдал

- I. доромжлогдсон нь
- II. дээш өргөгдсөн нь

Христийн үйлчлэл

- I. оршил: Зөнч
- II. тэргүүн тахилч
- III. золилтын учир шалтгаан ба зайлшгүй байдал
- IV. золилтын мөн чанар
- V. золилтын талаарх номлолууд
- VI. золилтын зорилго ба үр нөлөө
- VII. Христ зуучлагч болох нь
- VIII. Хаан

Энд зохиогч өөрийн уншигчдад ортодокс буюу үнэн зөв сургаалыг хүргэхээр зорьсон байгаа нь эргэлзээгүй байна.

Өнгөрсөн үеийн теологичдын хувьд аливаа нэг үзэл санааг христ итгэлийн туйлын үнэн хэмээн итгүүлэх нь харьцангуй хялбар байсан юм. Одоо бол өөр хэрэг. Орчин цагийн мэдээлэл холбооны хөгжил, хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас бид өөр бусад шашинтай байнга нүүр тулж байна. Олон хүн бүр төөрөлдөж гүйцээд хаана нь чухам үнэн, юу нь чухам зөв болохыг олж тогтоох хүчин мөхөсдөх болжээ.

Тэрч байтугай олон христ итгэлт теологичид бидний итгэлийн уламжлал үнэн гэдэгт хэр итгэлтэй байж болох талаар ч бодож эхэлсэн байна. Христ итгэлд ийнхүү төөрөгдөл үүсгэх нөлөө гаднаас байгаа төдийгүй сүм дотроо ч мөн зөвшилцөл үгүй байгааг анзаарахгүй байж боломгүй юм. Тун цөөхөн итгэгч шалихгүй цөөхөн асуудлаар бусадтайгаа санаа нэгдэхэд бэлэн байдаг. Өөрөөр хэлбэл Сүмийн дотоод дахь санал зөрөлдөөн нь ортодокс буюу үнэн зөвд хүрэхэд асуудал үүсгэж байгаа хэрэг.

Хэдийгээр байдал ийм байгаа ч ортодокс буюу зөв сургаалыг дагах нь теологийн чухал зорилгын нэг байсаар байх ёстой. Бидэнд тулгарч байгаа бэрхшээлүүд нь ямар нэг онцгой зүйл биш ээ. Иймэрхүү үзэл бодлын зөрөлдөөнтэй

тухайн цагтаа Христ болон түүний төлөөлөгч нар ч тулгарч байсан билээ. Гэхдээ Есүс өөрийнх нь дагалдагч нар үнэнд тэмүүлэхээр дуудагдсан гэдгийг итгэлтэйгээр тунхаглаж Эцэгтээ хандан:

“Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн мөн” /Иоган 17.17/
хэмээн залбирч байсан юм.

Сургаал номлолын үнэнийг Есүс тун чухалд тооцож байсан. Тэрээр теологийн хамгийн чухал зорилгын нэг нь ортодокс хэмээн онцлон тэмдэглэж байсан. Тэгвэл Түүний дагалдагчдын хувьд бид ч мөн ийм байвал зохино.

Одоо теологийн ортопрактик зорилгыг авч үзье.

Ортопрактик

Одоо теологийн ортопрактик зорилгыг авч үзье. Энгийн үгээр хэлэх юм бол теолог нь зөв үйлдэлд хөтлөх ёстой. Теологийн мөн чанар нь Ертөнцийн Эзэний өмнө амьдрах тухай сургаал юм хэмээн Уильям Эймс хэлснийг санацгаая. Ертөнцийн Эзэний өмнө амьдрах амьдралын нэг тал нь та бидний үйлдэл юм. Теологийн зөв үзэл санааг ойлгоод зогсохгүй тэдгээрийг практикт хэрэгжүүлэх хэрэгтэй.

Христ итгэлийн теологи нь биднийг зөв үйлдэлд хөтлөх ёстой нь ойлгомжтой. Жишээ нь теологи нь биднийг гуйж залбирах, сайн мэдээг тунхаглах, Ертөнцийн Эзэнийг хүндэтгэх, бие биедээ үйлчлэх, ядарсан хүнд туслах хэрэгтэй хэмээн сургадаг. Гэхдээ Христ итгэлийн теологи нь эдгээр болон бусад үнэний мэдлэгээр хязгаарлагддаггүй. Эдгээр үнэн нь зөв үйлдэл буюу ортопрактикт илэрхийлэгдэх ёстой юм.

Энд л эвангел итгэгчид томоохон бэрхшээлүүдтэй тулгардаг. Нэгдүгээрт, ёс суртахууны туйлын хэм хэмжээ гэж байдаггүй юм, бидний үйлдэлд сайн муу гэж байхгүй гэсэн худал хуурмагийг энэ дэлхийн амьдрал бидэнд тулгаж байдаг. Та бидний олонх нь дэлхийлэг соёлын нийтлэг урсгалын эсрэг байнга сөрж, зөв буруу үйлдэл гэж байдаг юм аа хэмээн нотолсоор бүр туйлдаж байна.

Тэрчлэн ортопрактикийн зарим нэг шийдмэг бус байдал нь өнгөрсөн үе дэх Сүмийн гаргасан алдаатайтай холбоотой юм. Үнэний төлөө нэрээр Сүм олон гэм үйлдсэн билээ. Түүний түүхээс үзвэл тэдгээр гэмийг нэлээд ул суурьтай гэмээр теологийн үндэслэлтэй үйлдсэн байдаг. Шашинлаг хүмүүс, тэрч байтугай жинхэнэ итгэгчид гэмээ зөвтгөхийн тулд теологийг үргэлж ашигладаг нь түүхийн гашуун бөримт юм.

Гэвч иймэрхүү асуудлууд байгаа ч ортопрактик нь шийдвэрлэх ач холбогдолтой, учир нь бидний үйлдэл нь Ертөнцийн Эзэнд чухал байдаг. Тэнгэр дэх бидний шагнал нь та бидний сайн муу үйлдлээс шалтгаална. Бидний сайн үйлс нь итгэгч ахан дүүсийн маань хэрэгцээ шаардлагыг хангахад Ертөнцийн Эзэний ашиглах хэрэгсэл, үл итгэгч ертөнцөд Христийн тухай гэрчлэл болж болох юм. Энэ болон бусад шалтгааны улмаас ортопрактик нь теологийн чухал зорилго байсаар байгаа билээ. Энэхүү зорилгыг биелүүлэхдээ нэлээд анхаарал болгоомжтой байвал зохилтой. Бидний аливаа үйлдэл дуулгавартай байдал ба хайраар ялгарсан байх ёстой юм. Христ итгэлийн амьдралыг гагцхүү үйлс хэмээн үзэж болохгүйн адилаар

теологийн зорилго нь зөвхөн зөв үзэл санаа байж боломгүй. Юу нь зөв зүйтэй болохыг мэддэг хэрнээ түүнийгээ эс үйлдэгчдэд хандан.

Иаков “Ертөнцийн Эзэн бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг. Чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг бөгөөд чичирдэг юм” /Иаков 2.19/.

гэснийг санацгаая. Энэ утгаараа сатан хүртэл зөв бодолтой байгаа биз, тэгээд юу болов?

Сатан Ариун Гурвалд болон Есүс гэмтний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэдэг, тэр нигүүлслээр итгэлээр аврагдах тухай сайн мэдээг ч мэддэг гэж би баттай боддог. Гэвч эдгээр үнэн түүний хувьд мөнхийн үнэ цэнэгүй юм. Учир нь тэр ортодокс буюу зөв үзэл бодлоос ортопрактик буюу Цорын ганц Эзэнийг хүндэтгэх үйлчлэл рүү хандсангүй. Тэгэхээр зөв үйлсийг христ итгэлийн теологийн хоёрдогч асуудал хэмээн үзэх уруу татлагыг эсэргүүцэх нь зүйтэй бөгөөд ортопрактик нь теологийн чухал үүрэг зорилгын нэг байсаар байна.

Ортодокс болон ортопрактикаас гадна теологийн бас нэгэн зорилгын тухай ярих хэрэгтэй юм. Түүнийг ортопафос хэмээн нэрлэе. Өөрөөр хэлбэл зөв мэдрэмж.

Ортопафос

Ертөнцийн Эзэний төлөөх амьдрал гэдэг нь Түүнд өөрийн сэтгэл хөдлөлөөр буюу баяр баясгалан болон гуниг гутрал, тэмүүлэл ба тааламж, уур болон бусад сэтгэл мэдрэмжээрээ үйлчилнээ гэсэн үг юм. Эдгээр нь бүгд Ертөнцийн Эзэний хүсэл зоригт нийцсэн байх ёстой. Харамсалтай нь теологчид чухамхүү энэ л зорилгыг анхаарахгүй алдах нь энүүхэнд байна. Теологчид сэтгэл мэдрэмжийг хоёр шалтгааны улмаас нэг их тоодоггүй байна.

Эхнийх нь олон теологч эрдэмтэд сэтгэл зүйн хувьд сэтгэл мэдрэмжийг илэрхийлэх, шинжлэн судлах чадваргүй байдаг. Тэрч байтугай цэвэр академик загварчлалын шууд нөлөөн дор олон хүн чухамхүү амьдралын сэтгэл хөдлөлийн талтай нүүр тулахгүйн тулд теологийн шинжлэх ухаанд амьдралаа зориулсан байдаг. Тийм ч учраас теологийн бүтээлүүд нь сэтгэл хөдлөл, баяр баясгалан, сэтгэлийн зовнил, харамсал зэргийг огтхон ч илэрхийлдэггүй ботаникийн сурах бичиг шиг байдаг нь гайхаад байхаар зүйл биш ээ. Хэрэв та теологийн ном уншдаг бол тэдгээр нь хүний мэдрэмжийн асуудалд хичнээн бага анхаардагийг нь мэддэг байх. Энэ нь мэргэжлийн теологчид энэ асуудалд ач холбогдол өгдөггүй юм уу эсвэл өөрсдөө сэтгэл хөдлөлийн хувьд сайн хөгжөөгүйтэй холбоотой байдаг.

Хоёрдахь шалтгаан нь олон итгэгчид сэтгэл мэдрэмж бол ёс суртахууны хувьд төвийг сахисан ойлголт гэдэг үзэл бодлын занганд орсон байдагтай холбоотой юм. Аливаа нэг сэтгэл мэдрэмжийг зөв юм уу буруу гэж болохгүй хэмээн тэд ярьдаг. Ортопафос буюу зөв сэтгэл мэдрэмж хэмээх ойлголт өөрөө төөрөгдөл юм гэж тэд үздэг байна. Сэтгэл мэдрэмж нь ёс суртахууны хэм хэмжээнээс гадуур зүйл юм гэсэн нийтлэг үзэл нь Библигтэй нийцэхээсээ илүү сэтгэл судлалын зарим нэг онолтой таарах юм. Теологи ба ортопафосын нийцлийн гайхалтай жишээ бол Пуулийн захидлууд билээ.

Пуулийн анхаарлын төвд ортодокс буюу үнэнийг тууштай дагах асуудал байсныг бид бүгдээрээ мэднэ. Гэхдээ үнэний тухай ярихдаа Пууль өөрийн сэтгэл

хөдлөлийг нуугаагүй. Зөв сургаалын тухай эргэцүүлэлдээ тэр сэтгэл нь тун их хөдөлсөн байдаг.

Коринтынхонд илгээсэн захидалд тайлбар бичиж байхдаа би Пуулийн теологийн үндэслэл түүний сэтгэл хөдлөлтэй хэрхэн зэрэгцэж байгаад ёстой алмайрч байсан юм. Бас түүний бичсэн хамгийн их онолын гэгдэх Ром ном байна. 9-11р бүлэгт Ертөнцийн Эзэний төлөвлөгөөн дэх еврей болон харь үндэстний байр суурийн тухай гүн гүнзгий эргэцүүллийн дараагаар Пууль.

Аяа, Ертөнцийн Эзэний мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь ямар гүн гүнзгий вэ? Түүний шүүлтүүд нь ямар ухаарагдашгүй Түүний замууд нь ямар олж илрүүлэшгүй вэ? Учир нь хэн Эзэний оюун ухааныг мэдсэн бэ? Хэн Түүний зөвлөгч нь болсон бэ? Эсвэл энэ нь өөртөө эргүүлж төлүүлэхийн тулд хэн Түүнд урьдчилж өгсөн бэ? Учир нь Түүнээс, Түүгээр, Түүнд бүх юм байна. Түүнд алдар нь үүрд байх болтугай. Амен /Ром 11.33-36/ гэсэн байдаг.

Та хамгийн сүүлд хэзээ теологийн номноос үүнтэй адил зүйлийг олж харсан бэ?

ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Тэгэхээр бид теологийн гурван гол зорилготой танилцлаа. Одоо тэдгээрийн харилцан уялдаа холбооны талаар ярилцъя. Тэдгээр нь харилцан холбоотой тул аль нэгийг нь үл тоомсорлож болохгүй юм. Тэрхүү уялдаа холбоо нь тун нягт учраас гурван зорилгын аль нэгт нь хүрэх гэж хичээх хэрэггүй. Үүнийг бид ортодокс ортопрактик болон ортопафосын аль аль нь нөгөөгөө баяжуулж, төгс болгож байдгийг үзсэнээрээ мэдэх болно. Эхлээд ортодокс нь теологийн нөгөө хоёр зорилгод хэрхэн тусалж байгааг авч үзье.

Ортодокс

Тодорхой ортодоксын нөхцөлд ортопрактик ба ортопафос байх болно гэдгийг зарчмын хувьд олон итгэгч хүлээн зөвшөөрдөг. Нэн түүрүүнд үнэнийг ойлгосноор түүнийгээ өөрийн амьдралд хэрэгжүүлэх хэрэгтэй гэдгийг ямар ч теологич номлодог. “Миний үзэл бодол миний амьдралын хэв маягийг бүрдүүлнэ” гэсэн энгийн загварчлалыг итгэгчид голдуу ойлгодог байна. Үнэхээр ч тийм л юм. Үнэний тухай бидний мэдлэг хэрхэн яаж амьдарч байгаад маань нөлөөлдөг билээ.

Теологийн концепцуудыг судалснаар бид ортодокст ханддаг. Үнэнийг бид юу гэж ойлгож байгаагаас нэг бол бидний үйлдэл ба мэдрэмж баттай болж эсвэл тэдгээр нь эргэлзээтэй байдалд ордог байна. Та угаасаа л уян сэтгэлтэй бусдын зовлонг хуваалцдаг хүн байлаа гэж бодъё. Тэгээд та хүн бол Ертөнцийн Эзэний дүр төрх юм, ойр дотныхондоо өршөөнгүй байх нь чухал юм гэдэг Библийн үнэнийг олж мэдлээ гэж бодъё. Тэгвэл таны сэтгэл мэдрэмж болон бусдад туслах үйлсийг тань ортодокс үзэл бодол улам баттай хүчтэй болгож байгааг та олж мэдэх болно.

Гэхдээ ортодокс үзэл бодол нь бидний үйлдэл ба сэтгэл хөдлөлийг эргэлзээтэй байдалд ч оруулж болох юм. Жишээ нь амиа хичээгч харамч хүн байлаа гэж бодъё. Ядуусын зовлон зүдгүүрийг юман чинээ ч боддоггүй нэгэн байж. Тэгвэл ийм хүний үзэл бодол нь Библийн дагуу болж ирвэл өөрийн үйлс ба сэтгэл мэдрэмжээ эргэж нэг харах болно. Ийм маягаар ортодокс бүрэлдсэнээр бидний үйлс ба сэтгэл мэдрэмжийг нэг бол гүн гүнзгий баттай болгож нэг бол эргэлзэхэд хүргэж ортопрактик ба ортопафост нөлөөлдөг байна.

Ортопракис

Бид теологийн зорилгуудын уялдаа холбооны талаар ярилцаж байгаа билээ. Тэгвэл ортопрактик нь ортодокс ба ортопафост хэрхэн тусалдаг вэ? Бидний үйлдэл үзэл бодол ба сэтгэл мэдрэмжид маань хэрхэн нөлөөлдөг вэ? Нэг талаас бидний үйлдэл нэг бол бидний итгэл үнэмшлийн үнэнийг баталж нэг бол тэдгээрийг эргэлзээнд оруулдаг. Жишээ нь теологийг нэлээд ул суурьтай судалж байгаа хүнээс та “гуйж залбирах ямар хэрэгтэй юм бэ? “

гэж асуулаа гэж бодъё. Хэрэв тэр хүн гуйлтын талаар нэг их туршлагагүй бол “Ертөнцийн Эзэн тэгж тушаасан учраас бид залбирдаг юм” гэсэн өнгөцхөн хариулт өгнө. Библи үнэхээр биднийг гуйж залбирахад уриалдаг. Гэхдээ амьдралд нь гуйлт залбирал тун чухал байр суурь эзэлдэг хүмүүсээс би ийм хариу хэзээ ч сонсож байгаагүй билээ. Гуйлт залбирлын олон жилийн туршлага нь залбирах олон шалтгааныг олж харах боломж өгдөг байна. Үнэхээр Ертөнцийн Эзэн хүссэн учраас гуйх нь зүйтэй. Гэвч залбирлын туршлага бага байх нь гуйх олон үндэслэлийг олж харахад маань саад болдог.

Нөгөө талаас бидний үйлдэл бидний ортодоксийг баттай болгож чадах юм. Хэрэв итгэгч хүн олонтаа гуйж залбирах аваас Бичээст өгөгдсөн гуйх шалтаг шалтгааныг илүүтэй ойлгож эхэлнэ. Ертөнцийн Эзэн гуйлгах эрхтэй учраас бид гуйдаг юм. Тэр бидэнд хэрэгтэй учраас бид гуйдаг.

Иаковын онож хэлснээр “зөвт хүний залбирал ...ихийг гүйцэлдүүлж чаддаг” учраас бид гуйдаг.

Зөв зүйтэй практик хангалтгүй байгаагаас болж бидний теологийн итгэл үнэмшил суларч, харин ариун амьдралын туршлага нь бидний итгэл үнэмшлийг засч залруулж баттай болгодог байна.

Тэрчлэн бидний үйлдэл нь сэтгэл мэдрэмжид маань нөлөөлдөг. Та бидний хийж байгаа зүйл мэдрэмжийг маань нэг бол баттай ноттой болгож нэг бол эргэлзээнд оруулдаг. Жишээ нь гэм хийчихсэн бол итгэгч хүн сэтгэл зовж буруутайгаа мэдэрнэ. Харин зөв зүйтэй үйлдэл хийсэн бол Ертөнцийн Эзэний урамшуулал ивээлээс баяр хөөрийг мэдэрдэг.

тэгэхээр бидний үзэл бодол үйлс ба сэтгэл мэдрэмжид маань нөлөөлдөг бол бидний үйлдэл сэтгэл мэдрэмж ба итгэл үнэмшилд маань нөлөөлдөг байна. Одоо теологийн зорилгуудын харилцан уялдааны тухай асуудлын төгсгөлд сэтгэл мэдрэмж хэрхэн итгэл үнэмшил ба үйлдэлд нөлөөлдөгийг авч үзье.

Ортопафос

Үүнийг дууллууд гэрчилдэг. Дууллыг зохиогчийн бодол санаа үйлдэл нь түүний сэтгэл хөдлөлийн нөлөөн дор байгаа нь илэрхий харагддаг. Өөрийгөө хаягдаж хоцорсон гэж бодох үедээ тэр юун түрүүнд туулж байгаа зовлон зүдгүүр болон энэ зовлон шаналал дунд Ертөнцийн Эзэнд итгэх итгэл нь ямаршуу байр суурь эзэлж байгаа тухай эргэцүүлсэн байдаг. Дуулал 13-т Давид:

**Эзэн минь хэдий болтол юм бэ? Та намайг үүрд мартаж юм уу?
Хэдий болтол Та надаас нүүрээ нуух юм бэ? ... Эзэн минь тунгаан
бодож надад хариулаач...” /дуулал 13:1, 3/ хэмээн дуу алдсан
байдаг.**

Сэтгэл мэдрэмж үйлдэлд ч мөн нөлөөлдөг байна. Дууллыг зохиогч гуниг зовлонтой байхдаа зүгээр суусангүй. Тэрээр зовлон шаналалд автаж орь дуу тавьж байна. Дуулал 6:6-д:

**“Би ёолсоор эцэж ядарч байна. Шөнө бүр би ороо нулимсанд
хөвүүлж дэвсгэрээ ч нулимсаараа нэвт норгодог” гэсэн байдаг.**

Харин баяр хөөрөөр дүүрэн байхдаа тэрээр үүнийгээ магтаал, талархлын үгээр илэрхийлж байна. Дуулал 30:11-т:

**“Та надад уй гашууг минь бүжиг болгосон. Та тааран хувцсыг
минь тайлан надад баяр хөөрийг өмсгөсөн.” гэжээ.**

Эдгээр жишээ нь теологийн гурван зорилго болох ортодокс, ортопрактик, ортопафосын харилцан уялдаа холбоог харуулж байна. Бидний итгэл үнэмшил ямагт сэтгэл мэдрэмж ба үйлдэлд маань нөлөөлдөг бол бидний үйлдэл итгэл үнэмшил ба сэтгэл хөдлөлд нөлөөлдөг. Харин бидний сэтгэл мэдрэмж үйлдэл ба үзэл бодолд маань нөлөөлдөг байна.

Тэгэхээр теологийн гурван зорилго харилцан холбоотой байдаг байна. Гэхдээ тэдгээрийн аль нэг нь бусдаасаа арай илүү чухал байдаг болов уу? Ортодокс, ортопрактик ба ортопафосын алинд нь илүү анхаарах ёстой вэ?

НЭН ТЭРГҮҮНИЙ ЗҮЙЛС

Олонх итгэгчид үүнд тун тодорхой хариу өгдөг. Бид эхлээд зөв үзэл бодолтой болж улмаар үзэл бодол нь бидний үйлдлийг өөрчилж дараа нь бидний үйлдэл сэтгэл хөдлөлийг маань өөрчилнө. Үүнийг л Ертөнцийн Эзэн хүсдэг хэмээн тэд итгэлтэй байдаг. Үүнийг “Зөв бод, зөв үйлд, тэгвэл өөрийгөө зөв зүйтэй байна гэж мэдрэх болно” гэсэн байдлаар томъёолж болох юм. Ийм байр суурь нэлээд түгээмэл байдаг байна.

Эргэлзээгүй энэ нь хууль ёсны хандлага. Энд ямар нэг алдаа мадаг алга. Гэхдээ бид үүнийг ямагт дагавал асуудал гарч ирэх л болно. Бодол эргэцүүлэл нэн тэргүүнд тавигдаж улмаар бидний теологи бүхэлдээ ядмаг болох болно. Учир нь үйдлийн теологи болон сэтгэл мэдрэмжийн теологийг бид хоёрдугаар зэрэгт тавих юм уу эсвэл бүр огт хэрэгсэхгүйд хүрэх юм.

Теологийг хүний биетэй жишиж үзвэл нэлээд дөхөмтэй байх болов уу. Хүний бие төв мэдрэлийн, хоол боловсруулах, амьсгалын, зүрх судасны гэх зэрэг хэд хэдэн амин чухал системээс тогтдог гэдгийг бүгд мэднэ. Тэдгээрийн алийг нь нэн чухал гэх юм бэ? Тэдгээрийн уялдаа холбоог ямар дарааллаар авч үзэх ёстой вэ? Эхлээд мэдрэлийн систем хоол боловсруулахад хэрхэн нөлөөлж байгааг авч үзэж болох юм. Гэтэл хоол боловсруулалт мөн л мэдрэлийн системд нөлөөлж байдаг шүү дээ. Өөрөөр хэлбэл эдгээр системүүдийн хоорондын уялдаанд цорын ганц журам дараалал байх боломжгүй юм.

Тэгэхээр бид теологийн гурван зорилгын аль нэгийг тэргүүнд тавих боломжгүйг харлаа. Энэ цуврал хичээлээр бидний итгэл үнэмшил, үйлдэл болон сэтгэл хөдлөл нь олон янзын уялдаа холбоо бүхий систем юм аа гэдгийг дахин дахин давтах болно. Энэ нь шугаман бус харин олон шугамт, олон талт харилцааны систем бөгөөд энд тэргүүлэгч үгүй юм. Үнэхээр зөв үйлдэл хийгээд дараа нь зүйтэй зөв юм гэж мэдрэхийн тулд бид зөв бодож санах ёстой. Гэхдээ зарим үед зөв ойлгож зөв мэдрэхийн тулд зөв үйлдэх ёстой. Мөн зөв бодож, зөв үйлдэхийн тулд зөв мэдрэх ёстой юм. Арийн Сүнс өөрийн хүмүүсийг теологийн зорилго руу янз бүрийн арга замаар хөтөлдөг байна.

Тэгэхээр яах вэ? Юунд илүү анхаарах вэ? Зөв бодол эргэцүүлэлд үү, зөв үйлдэлд үү, зөв мэдрэмжид үү? Үүнд нэг л хариулт байна. Тодорхой нөхцөл байдал бүрт юу нь зайлшгүй вэ гэдгээс аль нэгт нь илүүтэй анхаарах ёстой юм.

Бид хоёр тийшээ ганхаж байгаа хөлөг онгоцны тавцан дээр явж байгаа юм шиг амьдарч байна. Тэнцвэрээ олохын тулд хөлөг онгоцны хөдөлгөөнөөс хамаарч аль нэг тал руу нь хазайж сурах л хэрэгтэй юм. Хэрэв бид ингэхгүй юм бол хөлөг нэг тал руу ганхах үед тавцангаас шидэгдэж мэднэ. Теологийн асуудлуудыг судлахад байнгын ямар нэгэн тогтсон журам гэж байдаггүй. Теологийн зорилгод хүрэхийн тулд өөрөөсөө “ямар хэрэгцээ шаардлага байна? Бидэнд болон бидний эргэн тойронд байгаа хүмүүст хамгийн түрүүнд юу хэрэгтэй байна вэ?” хэмээн асуух хэрэгтэй юм. Тэгвэл бид тухайн үедээ тохирсон баримжааг тогтоож теологийн бүхий л зорилгод хүрэхийн тулд зүрх сэтгэлээрээ тэмүүлэх болно.

Юу нь чухал болохыг тухайн цагт нь тогтоож чаддаггүй итгэгч хүний амьдралд олон таагүй зүйл тохиолдож болох юм. Ортодоксийг ямагт түрүүнд тавьснаар бид дан ганц оюунлаг байдлыг шүтэгч болж хувирна. Үйлдлийг ямагт чухалчилснаар бид хууль баримтлагч болно. Сэтгэл мэдрэмжээ хэт анхаарснаас бид хэт хөөрөлд автаж болох юм. Амьдралын хөлөг онгоц ганхах үед тэнцвэрээ олж сурснаар бид энэхүү хэт туйлшралд автахгүй байж чадна. Хүн бүр өөрөөсөө: ”эдгээр хандлагаас аль нь миний теологт илүү байна? Оюун ухаан уу? Хуульчлал уу, эсвэл сэтгэл хөдлөл үү? Аль эсвэл эдгээрийг хослуулж байна уу?” гэж асуух хэрэгтэй юм. Бидний анхааралд огтхон ч өртөхгүй байгаа теологийн тэрхүү зорилгод л хүрэхийн тулд бид чармайх ёстой.

За тэгэхээр бид теологи гэж юу болохыг тодорхойлж зорилгыг нь тогтоолоо. Одоо гурав дахь асуудал руугаа орж теологийн сэдвүүдийг авч үзье. Теологи

судлахдаа бид юуг илүү сонирхдог вэ? Ортодокс, ортопрактик, ортопафосын зорилго руу ямар зүйлээр дамжин очих вэ?

Хэлэлцэх асуудал

Хэн нэгнийг теологитэй танилцуулах нь түүнийг орчлон ертөнцтэй танилцуулахтай адил хэрэг юм. Энэ нь өргөн цар хүрээгээрээ зүрх алдахад хүргэдэг. Тийм учраас бид хичээлээрээ теологийн зарим нэг сэдвийг л хөндөх болно. Гэхдээ эхлээд ямар хувилбарууд байдаг, ямар байдлаар бид сонголтоо хийх вэ гэдэг хоёр асуултанд хариу өгөх хэрэгтэй юм.

ХУВИЛБАНУУД

Ерөнхий теологийг судлахаар зориг шулуудсан хүн ямаршуухан талбарт судалгаа хийх вэ? Дөнгөж эхэлж байгаа хүнд энэ талбар цар хүрээгээрээ гайхуулдаг. Теологи олон асуудал сэдвийг хамардаг гэдгийг бүгд мэднэ. Христ итгэлийн түүхийн 2 мянган жилийн хугацаанд теологи сонирхож байсан хүмүүсийн анхаарлыг олон олон асуудал татаж байсан юм. Сүмүүдэд эдгээр асуудал янз бүр байж болон боловч теологийн үндсэн категоруудыг тогтоож болох ерөнхий асуудлууд байдаг.

Теологи нь илгээлтийн үйлчлэл, сайн мэдээ тараах, христ итгэлийн үнэнийг гэрчлэх буюу апологетик, хүндэтгэл магтаал, нигүүлслийн үйлчлэл, зөвлөгөө өгөх, гомилетик буюу багшлах чадвар гэх зэрэг нэлээд практик сэдвүүдийг голдуу авч үздэг билээ. Тэрчлэн сотериологи буюу авралын тухай номлол, еклесиологи буюу сүмийн тухай номлол, антропологи буюу хүний тухай номлол, пневматологи буюу Ариун Сүнсний тухай номлол, христологи буюу Христийн тухай номлол, Ертөнцийн Эзэний тухай номлол, эсхатологи буюу сүүлчийн өдрүүдийн тухай номлол, библийн теологи буюу Библи дэх золилтын түүхийн теологи, системт теологи буюу сэдэвчилсэн библийн сургаалын логик тайлбар, түүхэн теологи буюу сүмийн түүхэн дэх номлолуудын хөгжлийн судалгаа болон герменевтик буюу Бичээсийн тайлбар гэх зэрэг илүү онолын талын аврага том цогцыг багтаасан байдаг.

Уламжлалт академик теологи нь эдгээр асуудлуудыг ортодоксын бхйр сууринаас голдуу авч үздэг. Өөрөөр хэлбэл энэ бүгдийг хэрхэн зөв ойлгох вэ гэдгийг авч үздэг байна. Семинарын хичээлийн нийтлэг хандлага нь зайлшгүй чухал асуудлыг мэдэж авах, тэдгээрийг зөв ойлгоход чиглэнэ. Зарим нэг семинарын дамжаа нь практик дадлыг ч мөн олгоно. Хүндэтгэл, сайн мэдээ, гомилетик эсвэл зөвлөгөө өгөх тухай хичээлүүд ортопрактикт зориулагдсан байдаг. Харин харамсалтай нь семинарын хичээлүүд, тэр ч байтугай гомилетикийн курсууд ортопафост зохих ёсоор анхаардаггүй байна. Гэхдээ бид энэ хичээлээрээ теологийн гурван зорилгод хүрэхийг эрмэлзэх нь туйлын зөв хандлага гэж үзсэн байгаа. Өөрөөр хэлбэл, теологи судалж байгаа хүний өмнө асар том үүрэг байна гэсэн үг. Теологийн асуудал бүр олон талт үйл ажиллагааг шаардаж байдаг байна.

СОНГОЛТУУД

Асар олон сэдэв ба хувилбар байгаа нь зайлшгүй сонголт хийхэд хүргэнэ. Теологи судалж эхлэхэд дэндүү олон тэгээд бас хүнд сэдвүүдээс болж сүрдэн алмайрахад хүрэх аюул нүүрлэж байдаг. Теологийн судалгааны талбар дэндүү том учраас олон хүн нэр гарчиг төдийхөн танилцаад цааш явахыг хүсдэггүй. Үүнээс болж тэд зөвхөн ортодоксийг анхаарахаас өөр аргагүй болдог байна.

Энэхүү цуврал хичээлээрээ бид сэдвийн тоог хязгаарласнаар дээрх аюулаас зайлсхийх болно. Бид пасторын үйлчлэлд илүүтэй чухал асудлуудыг авч үзэх юм. Өөрөөр хэлбэл сүмийн үйлчлэгчдэд тун хэрэгтэй байдаг итгэл үнэмшил, үйлдэл ба сэтгэл мэдрэмжийн талуудыг авч үзнэ гэсэн үг. Бид нэвтэрхий толийн хэмжээнд хүрэх гэж хичээхгүй. Харин “үйлчлэлд гарах гэж байгаа хүн теологийн үүднээс үзвэл юуг мэдэж, үйлдэж, мэдэрч байх ёстой вэ?, Теологийг хэрхэн судлах вэ?” гэсэн асуултын хариуг олж авах болно.

Эдгээр асуултын хариуг нээж олох шаардлагагүй юм. Хэд хэдэн чухал чигийг сүм хэдийнэ тодорхойлчихоод байгаа билээ. Теологийн боловсрол зуун зуунаар дамжин хөгжиж, янз бүрийн урсгал чиглэлийн дунд удирдагчдын боловсролд чухам ямар сэдвүүдийг оруулах тухайд нэгдсэн нэг санаа тогтсон байна.

Үүний дүнд ердийн сургалтын хөтөлбөр дараах маягтай болжээ. Хөтөлбөр нь библийн, түүх-номлолын, практик гэсэн үндсэн гурван хэсэгтэй. Удирдагчдад зориулсан теологийн бэлтгэлийн энэхүү гурван чиглэлд сүмийг Ариун Сүнс хөтөлсөн байна. Тэгэхээр эдгээр чиглэлийг авч үзье.

Библийн хэсэг нь голдуу Хуучин ба Шинэ гэрээг судалдаг. Сургалтын хөтөлбөр нь Бичээсийн агуулга ба Библийг нарийн тайлбарлах дадлагад анхаарсан байдаг.

Түүх номлолын хэсэг нь голдуу сүмийн түүх ба системт теологиос бүрддэг. Сүмийн түүх нь энэ дэлхийг янз бүрийн цаг хугацаанд сөрж зогсож байсан сүмийн теологийг Ертөнцийн Эзэн хэрхэн бий болгосныг анхаарч үздэг. Системт теологи нь библийн сургаалыг сүм хэрхэн логик системд оруулсныг өгүүлдэг байна.

Практик хэсэг нь суралцагчдын анхаарлыг тэдний өөрсдийнх нь сүнслэг өсөлт болон номлол сайн мэдээ зэрэг үйлчлэлийн дадалд өсөхөд нь хандуулдаг байна. Энэ бүтэц үр ашигтай гэдгийг бид цуврал хичээлээрээ үзнэ. Бид өөрсдийн чиг хандлагыг гаргах гэж оролдолгүйгээр харин сүмд Ариун Сүсний аль хэдийнэ зааж өгснийг сурч авахыг хичээх болно.

Бид өөрсдийн хичээлээр мөн л гурван үндсэн сэдвийг хөндөх юм. Библийн хэсэгт нь Экзегетик буюу тайлбар хэмээх сэдэв байх юм. Түүх номлолын хэсэгт нь “Хамтын нийгэмлэг дэх харилцан үйлчлэл”, практик хэсэгт нь “Христэч амьдрал” хэмээх сэдвийг авч үзнэ. Теологийг судлахдаа бид энэ сэдэв бүрийг тус тусад нь авч үзэхээс гадна тэдгээрийг харилцан уялдаа холбоонд нь авч үзнэ. Хэт туйлшралаас болгоомжилж сэдэв бүр үзэл санааны, практик болон сэтгэл мэдрэмжийн талтай гэдгийг ямагт санаж байвал зохино.

Хуучин ба Шинэ гэрээг тайлбарлахдаа бид онол, практик, мэдрэмжийн аль алинд анхаарал хандуулж сурах хэрэгтэй юм.

Сүмийн хамтын нийгэмлэгийн дотоод харилцаа холбоог судлахдаа бид мөн л онол, практик, мэдрэмжийн аль аль нь чухал болохыг мартаж болохгүй.

Христэч амьдралыг судлахдаа бид ортодокст анхаараад зогсохгүй ортопрактик, ортопафост ч мөн анхаарал хандуулах ёстой. Теологийн оршил энэхүү курст “Экзегетик”, “Хамтын нийгэмлэг дэх харилцаа холбоо”, “Христэч амьдрал” хэмээх сэдвүүд чухал байх болно.

Дүгнэлт

Энэхүү хичээлээр бид “Теологи гэж юу вэ? хэмээх үндсэн асуултын авч үзлээ. Теологийн тодорхойлолт, зорилго, хэлэлцэх асуудлууд хэмээх гурван талыг хөндсөн. Энэ хичээлээр үзсэн зүйлсээ бид дахин эргэн харах болно. Тогтсон гурван чиг хандлагыг марталгүйгээр бид теологийн хичээл, Христ ба Түүний сүмд үйлчлэх үйлчлэлд илүү сайн бэлтгэлтэй байж чадах юм.

Dr. Richard L. Pratt, Jr. (Host) is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open*, *Every Thought Captive*, *Designed for Dignity*, *He Gave Us Stories*, *Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.